

11

**ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА**

Д. Тунгалааг

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хуулиар гадаадын хөрөнгө оруулалт гэдэг нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсвэл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ гэж заасан байдаг. Уг хуульд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгийн 25 хувиас доошгүй нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь байхаар тогтоосон нь Олон улсын валютын сангаас заасан хувийг хангаж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд дэлхийн ихэнх оронд эдийн засгийн өсөлт сул, ойрын үед эдийн засаг нь сэргэх ирээдүй бага, хөрөнгийн зах зээлийн үнэ ханш унасан, компанийн ашиг орлого бага, зарим салбарын үйлдвэрийн өөрчлөн зохион байгуулалтын явц саарсан, зарим орны хувьчлал буурсан зэрэгтэй холбогдон гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/-ын урсгал дэлхийн хэмжээнд буурах хандлагатай байгаа боловч бус нутаг дотроо, ялангуяа Зүүн өмнөд Ази, Зүүн хойд Азид хүчтэй байгаа. Үүний дотор Монголд орж байгаа ГШХО-ын хэмжээ сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдсээр байгаа.

Монгол улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтын асуудалд өндөр ач холбогдол өгч, түүнийг урамшуулан дэмжсэн гадаад, дотоод эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байгаа билээ.

Монгол улсад хөрөнгө оруулах, ялангуяа Зүүн хойд Ази, Хойд Америкийн хөрөнгө оруулагчдын сонирхол сүүлийн жилүүдэд өсч байгаа бөгөөд уул

урхай, хөнгөн үйлдвэр, худалдаа үйлчилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулалт түлхүү орох боллоо.

2003 оны эцсийн байдлаар 1990 оноос хойш 73 орноос 3042 компани нийтдээ 1 тэрбум ам. долларын хөрөнгө Монголд оруулахаар бүртгүүлсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаар авч үзвэл геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт ГШХО-ын 46,2 хувь, худалдаа үйлчилгээний салбарт 12,8 хувь, оёдол, сүлжмэлийн үйлдвэрт 8,3 хувь, малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулалтанд 5 хувь, барилгын үйлдвэрлэлд 5 хувь, банк, санхүүгийн үйл ажиллагаанд 3,1 хувь тус тус орсон байна.

Хүснэгт 1

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ, салбараар

№	Улс	Оруулсан хөрөнгө (мян. ам. доллар)	Эзлэх хувь
1	Геологи хайгуул, уул уурхай, газрын тос	462,076	46,2
2	Худалдаа, нийтийн хоол	128,466	12,8
3	Хөнгөн үйлдвэр	83,338	8,3
4	Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах	50,267	5,0
5	Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэр	49,502	5,0
6	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	31,467	3,1
7	Тээвэр	20,957	2,1
8	Харилцаа холбоо	20,924	2,1
9	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	17,540	1,8
10	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	14,387	1,4
11	Аялал жуулчлал	11,424	1,1
12	ХАА, газар тариалан	9,510	1,0
13	Бусад	100,527	10,1
	Дүн	1000,385	100,0

Эх сурвалж: ГХОГХА

Харин хөрөнгө оруулагчдын харьяалагдах улс орноор авч үзвэл Зүүн хойд Ази, Хойд Америкийн хөрөнгө оруулагчид түлхүү хөрөнгө оруулалт хийснээс БНХАУ-ын хөрөнгө оруулагчид Монголд орсон хөрөнгө оруулалтын 37,9 хувиар хөрөнгө оруулагчдын жагсаалтыг тэргүүлж, Канад улс 13,2 хувиар удаалж, АНУ (11.5 хувь), БНСУ (8.1 хувь), Япон (6,0 хувь), ОХУ (3,4 хувь) болон бусад орны (20,1 хувь) хөрөнгө оруулагчид дараагийн байруудад орж байна.

Хүснэгт 2

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ, улс орноор

№	Улс	Оруулсан хөрөнгө (мян. ам. доллар)	Эзлэх хувь
1	БНХАУ	379,010	37,9
2	Канад	132,518	13,2
3	АНУ	114,895	11,5
4	БНСУ	80,856	8,1
5	Япон	60,429	6,0
6	ОХУ	33,718	3,4
7	Болгар	27,215	2,7
8	Гонг Конг (БНХАУ)	21,646	2,2
9	Их Британи	21,309	2,1
10	Их Британий Виржини арал	17,953	1,8
11	Багамын арлууд	14,814	1,5
12	Тайвань (БНХАУ)	10,957	1,1
13	Итали	10,734	1,1
14	Сингапур	9,151	0,9
15	Бусад	65,180	6,5
	Дүн	1000,385	100,0

Эх сурвалж: ГХОГХА

2003 онд 653 компани нийт 203,8 сая ам. долларын хөрөнгө оруулахаар бүртгүүлсэн нь ДНБ-ний 17,5 хувьтай тэнцэж байгаа бөгөд өмнөх оныхтой харьцуулбал 10 хувиар өссөн байна.

Хүснэгт 3

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын харьцуулсан үзүүлэлт

№	Үзүүлэлт	2000	2001	2002	2003*
1	Дотоодын нийт бүтээгдэхүн-ДНБ, тэрбум төгрөг	1018,9	1115,6	1231,3	1363,2
2	Гадаадын шууд хөрөнгө оруулалт-ГШХО, сая ам.доллар	104,4	130,2	182,5	203,8
3	ГШХО/ДНБ, хувь	9,8	12,4	15,8	17,5
4	ГХОААН-ээс улсын төсөвт оруулсан татварын орлого, тэрбум төгрөг	40,4	39,5	37,3	
5	Иргэдийн хадгаламж-ИХ, тэрбум төгрөг	86,4	124,8	207,0	330,0
6	ИХ/ДНБ, хувь	8,5	11,2	16,8	24,2
7	Валютын жилийн дундаж ханш, 1 ам.доллар	1097,0	1102,0	1125,0	1168,0

Эх сурвалж: УСГ, Монгол улсын Статистикийн эмхтгэл, 1998, 2001, 2002

ГХОГХА

ҮТЕГ

-урьдчилсан байдлаар

Хөрөнгө оруулалтын хэмжээ ийнхүү нэмэгдэхэд шинэ хөрөнгө оруулагчдаас гадна Монголд хөрөнгө оруулаад үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчид зохих хувь нэмэр оруулсан байна. Тухайлбал, 2000-2003 онуудад гадаадын хөрөнгө оруулалттай 105-140 компани 29,5-141,5 сая ам. долларын хөрөнгө нэмж оруулж байсан нь тухайн оны гадаадаас орж ирэх хөрөнгө оруулалтын 28,3-69-2 хувийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 4

Гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудаас нэмж хөрөнгө оруулсан байдал

№	Хөрөнгийн хэмжээ	2000	2001	2002	2003
1	Нэмж хөрөнгө оруулсан компанийн тоо	124	105	118	140
2	Нэмж оруулсан хөрөнгө, сая ам.доллар	29,5	62,5	57,6	141,1
3	Тухайн оны ГШХО-д эзлэх хувь	28,3	39,0	31,6	69,2

Эх сурвалж: ГХОГХА

Одоогийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь ёссөн дунгзээр 70 гаруй мянган ажлын байр бий болгож, сүүлийн жилүүдэд Монголын нийт экспортын тал орчим хувийг гүйцэтгэж, төсөвт 40 орчим тэрбум төгрөгийн татварын орлого оруулж байгаа юм.

2003 оны байдлаар ГШХО-ын урсгал тогтворжиж 2004 оноос эхлэн өсөх хандлагатай байгаа бөгөөд Монгол улсын хувьд гадаадын хөрөнгө оруулагчид, ялангуяа, олон улсын уул уурхайн компаниуд Монголыг, түүний дотор геологи хайгуул, уул уурхайн салбарыг сонирхох сонирхол нэмэгдэх төлөвтэй байна. Үүнийг дараах хүчин зүйлтэй холбож үзэж болох юм.

Үүнд:

- Монгол улс нь Хятад, Оросын том зах зээлийн аль алинд нэвтрэн орох газар зүйн байршил сайтай;
- Манай орон ашигт малтмалаар баялаг, ялангуяа зэс, алтны нөөцөөр арвин;
- Монгол улсын Засгийн газраас Гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх чиглэлийн жагсаалтыг 2001 онд, Геологи, уул уурхайн салбарын талаар ойрын жилүүдэд баримтлах чиглэлийг 2002 онд тус тус баталсан;
- Гадаадын хөрөнгө оруулалтын чөлөөт горим болон Гадаадын хөрөнгө оруулалтын, Татварын, Гаалийн тухай Монгол улсын хуулиудаар гадаадын хөрөнгө оруулалт нь хамгаалалтанд байж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх боломж олгодог;

- 2002 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх хэлбэр, төрлийг нэмэгдүүлснээс гадна томоохон хөрөнгө оруулагчдад татварын тогтвортой нөхцөлд ажиллах бололцоог нээж өгсөн;
- УИХ-ас манай орны эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой Чөлөөт бүсийн тухай, "Алтанбулаг", "Цагаан нуур" худалдааны чөлөөт бүсүүдийн эрх зүйн байдлын тухай, "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг 2002-2003 онд батлан гаргасан.

Улс орны хөгжилд шийдвэрлэх үүрэг бүхий салбар (уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуй), бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ГШХО-ыг улам илүү татахад олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн энэ давуу талаа цаг алдалгүй шуурхай ашиглах, улмаар бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй шинэ техник технологи оруулж ирэх, ашиг орлогоосоо дахин хөрөнгө оруулах явдлыг хөхүүлэн дэмжих, байгаль орчин, хэрэглэгчдийг илүү сайн хамгаалах зэрэг асуудлыг гадаадын хөрөнгө оруулалттай холбон хэрэгжүүлэх нь чухал байна.